



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 05

Улиастай

**ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН
ТОВЧ ТАЙЛАН**

Аймгийн засаг даргын дэргэдэх СХДААлбаны 2022 оны санхүүгийн аудит, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улиастай сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг хангуулах, стандарт, заавар журмын хэрэгжилт, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт зэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тусалж, албаны даргын баталсан 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар удирдамжаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийв.

Хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, бүртгэл, хяналт

Хүүхдийн хоолны зарцуулалт нярвын тайлан болон ирцийн бүртгэлийн хүүхдийн тоотой тохирч, нормын дагуу зарцуулагдсан.

Харин 2020 онд “ковид-19” цар тахалтай холбогдон хичээл сургууль цөөхөн хоног / 66 хоног/ орсонтой холбоотой давхардсан тоогоор 17452 хүүхдэд 43184900 төгрөгийн хоолны зардал гарсан. Аймгийн онцгой комисс болон аймгийн БСУГ-ын даргын шийдвэрээр Өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, штабт ажиллаж байсан давхардуулсан тоогоор 269 хүнд 2446750 төгрөгийн хоол, зорилтот бүлгийн 15 хүүхдэд 1224950 хоолны материалыг олгосон.

2021 онд “ковид-19” цар тахалтай холбогдон хичээл сургууль цөөхөн хоног / 100 хоног/ орсонтой холбоотой давхардсан тоогоор 16982 хүүхдэд 42021100 төгрөгийн хоолны зардал гарсан. Аймгийн онцгой комисс болон аймгийн БСУГ-ын даргын шийдвэрээр Өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, штабт ажиллаж байсан давхардуулсан тоогоор 1180 хүнд 8260000 төгрөгийн хоол, вакцинжуулалтанд ажилласан багийн эмч, ажилчдын хоолны зардалд 63 хүнд 208000 тагрөгийн хоол өгсөн байна. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, вакцинжуулалтанд ажиллах, ажилласан хүмүүсийн тоо болон нэг хүнд ногдох хоолны зардлыг баталсан шийдвэр байхгүй байлаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, штаб, вакцинжуулалтад ажилласан хүмүүсийн хоолны зарцуулалтад тавих удирдлага, дотоод хяналтын ажлын хэсгийн хяналт маш сул байсан байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар илэрсэн зөрчил:

- Ажилчдын цалингаас суутгасан ҮЭ-ийн татвар, “Би гүймээр байна” хандивт нэг өдрийн цалин өгөөд өглөг, авлагын зөрүүг данс бүртгэлд тусгаагүй. Ажилчдын цалингаас дутуу суутгасан.

- Эрхлэгчийн ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн мөнгөн урамшууллыг цалингийн цэсээр оруулалгүй, НДШ, ХХОАТ суутгаагүй олгосон.
- Бараа материал дутуу орлогот авсан.
- Ажилчдын цалингаас суутгасан ХХОАТ болон иргээдээс худалдан авсан бараа материалын үнээс ХХОАТ суутган авч хуулийн хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй.
- Засвартай болон зах зээлийн үнээс өндөр үнээр үхрийн мах худалдан авсан.
- Эрхлэгчид спортын зэргийн нэмэгдэл олгосон.
- Сахилгын шийдвэр хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийдвэргүйд тооцох хугацаа дуусаагүй байхад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.
- 2021 онд томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй ур чадварын нэмэгдэл олгосон зэрэг зөрчлүүдтэй холбоотой нийт 7538883 төгрөгийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, баримтын бүрдэлт, тайлагналт нь НББОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн боловч "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүргэлийн тухай", "Хувь хүний орлогын албан татварын тухай" хууль Засгийн газрын 2018 оны 382 дугаар, 2019 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилт "Хангалтгүй" байна.

Цаашид хийх ажлын талаарх зөвлөмж

- 1.Төсвийг зориулалтын дагуу зарцуулж хэвших, дотоод хяналтыг сайжруулах
- 2.Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг санхүү, төсөл, хөтөлбөр, худалдан авалтын зардлуудад чиглүүлэн хяналт шалгалт хийж мэдээллийн ил тод байдлыг хангах, чадварлаг, хараат бус ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- 3.Шалгалтаар гарсан зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх. Актын төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулж хураан барагдуулалтын тайланг ирүүлэх.
- 4.Шалгалтаар илэрсэн зөрчлийг шийдвэр гаргасан болон гардан зохион байгуулсан, түүнд хяналт тавих эрх, үүрэг бүхий албан тушаалтан нар хариуцах бөгөөд нөхөн төлбөрийн актыг хавсралтанд нэр заагдсан албан тушаалтан нар хариуцан төлнө

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДА.СХШУАБ Б.БАТХҮҮ

